

ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын мэдээллийн хуудас 2019 оны 5 сарын дугаар

Тэргүүн мэдээ.

Монголын анхны SATREPS төсөл хэрэгжиж дууслаа.



“Тогтвортой хөгжлийн төлөөх шинжлэх ухаан, технологийн хамтарсан судалгааны хөтөлбөр”-ийн (SATREPS) хүрээнд Монголд анх удаа хэрэгжсэн “Малын цусны шимэгч, эгэл биетнээр үүсгэгддэг өвчний тархалтын судалгаа, оношлогооны оновчтой арга боловсруулах нь” төсөл 2019 оны 5 сард амжилттай хэрэгжиж дууслаа. 2014 оноос Обихирогийн МЭХААИС, ХААИС-ийн Мал эмнэлэгийн хүрээлэн хамтран Монгол улсын хэмжээнд цусны шимэгчээр үүсгэгддэг өвчний тархалтыг тодорхойлж, эдгээр өвчнийг түргэн хугацаанд найдвартай оношлох аргыг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн зэрэг олон амжилттай үр дүнд хүрсэн нь төслийн эцсийн шатны үнэлгээгээр өндрөөр үнэлэгдсэн билээ. Цаашид хамтарсан судалгааны ололт амжилтыг Монгол орны өнцөг булан бүрт нэвтрүүлсэнээр цусны шимэгчээр үүсгэгддэг өвчинтэй бодитоор тэмцэх боломжтой болох юм.

Төслийн хэрэгжилт.

Сургагч багш нарт зориулсан барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ ба хүчитгэлийн тухай сургалт (Training of Trainers) болж байна.



ТХА-ны “Монгол Улсын Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх төслийн” хүрээнд боловсруулсан барилга байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэржлийн оношлогоо, хүчитгэл, дэд бүтцийн байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэржилтийн оношлогооны гарын авлагыг ашиглан 2019 оны 5 -10 сард сургагч багш нарт зориулсан сургалтыг зохион байгуулахаар төлөвлөн хэрэгжүүлж эхлээд байна. Эхний ээлжинд 5 сарын 6-17-ны өдрүүдэд ОБЕГ, МХЕГ, БХБЯ, Барилгын хөгжлийн төвийн мэргэжилтнүүдийг хамруулсан сургалтыг зохион байгуулсан. Цаашид байгууллага тус бүрт шаардагдах технологийн түвшин, мэргэжилтнүүдийн ур чадварт тохирсон нарийвчилсан агуулга бүхий ур чадвар эзэмшүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах юм.

“Өсвөр үеийнхнийг эрүүл аж төрөх дадалд суралцуулах тогтвортой тогтолцоо байгуулах төсөл”-ийн хаалтын ёслолын арга хэмжээ боллоо.



5 сарын 28-ны өдөр Өвсний үндэс техникийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж буй “Өсвөр үеийнхнийг эрүүл аж төрөх дадалд суралцуулах тогтвортой тогтолцоо байгуулах төслийн” (Япон талын хэрэгжүүлэгч байгууллага нь Жичи Анагаахын ухааны их сургууль) хаалтын ёслолын арга хэмжээ зохион байгуулагдлаа. Энэхүү төсөл нь Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэгт 4 жилийн хугацаанд хэрэгжсэн бөгөөд өсвөр үеийнхэн залуучууд нөхөн үржихүйн болон эрүүл мэндийн талаар хоорондоо харилцан зөвлөлдөж, арга замаа олоход нь чиглүүлэх “Үе тэнгийнхэний зөвлөх үйл ажиллагааны ”тогтолцоог бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж ирсэн. Ёслолын арга хэмжээнд үе тэнгийн зөвлөхөөр бэлтгэгдсэн залуучууд болон холбогдох албаны төлөөлөл оролцсон ба цаашид үйл ажиллагаагаа бие даан явуулах итгэл, эрмэлзэл дүүрэн байгаа талаар дурьдсан юм. Цаашид үйл ажиллагааны үр дүнг тогтвортой үргэжлүүлж, цар хүрээг өргөжүүлэх хүлээлтийг дагууллаа.

"Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн тусламж үйлчилгээг сайжруулах, эцэг эх, мэргэжилтний чадавхийг сайжруулах" төсөл дуусах үеийн үнэлгээг хийв.



Өвсний үндэс техникийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж буй "Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн тусламж үйлчилгээг сайжруулах, эцэг эх, мэргэжилтний чадавхийг сайжруулах төсөл" нь "Нинжин (Япон талын хэрэгжүүлэгч ТББ) ба Монголын Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоотой хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засал, хөгжлийн 2 төвд төвлөрөн эцэг эхчүүдэд сэргээн засал, боловсролын үйл ажиллагааны дэмжлэг үзүүлж байна. 8 сард төсөл дуусах гэж байгаатай холбогдуулан 4 сарын 21-нээс 28-ны өдрүүдэд хийсэн төсөл дуусах үеийн үнэлгээгээр дээрх хоёр төвд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон асран хамгаалагчид тоглоом, дасгал, сэргээн заслыг эцэг эх асран хамгаалагчид гэртээ хийж хэвшил болгосон байна. Тэд төсөл дуусах хүртэл амжилтаа улам бататгахаар ажиллаж байна.

"Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл" "Bloomberg TV Mongolia Awards" шагнал хүртэв.



Иений хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй "Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл" 5 сарын 13-ны өдөр "Bloomberg TV Mongolia Awards"-ын "Оны шилдэг төсөл" шагнал хүртэв. Япон Монголын хамтын ажиллагааны бэлгэ тэмдэг болсон энэхүү төсөл 2018 оны хамгийн шилдэг төслөөр шалгарсан байна. Төслийн хүрээнд Нийслэлийн нисэх буудлын аюулгүй, тав тухтай байдлыг хангах үүднээс Улаанбаатар хотоос баруун урагшаа 45 км зайтай газар шинэ нисэх онгоцны буудал барьж байна. Шинэ нисэх онгоцны буудлын байгууламж нь улам бүр өсөн нэмэгдэх зорчигч урсгалыг дамжуулан өнгөрөөх боломж бүхий аялал жуулчлалын хөгжлийн түүчээ болохуйц бүтээн байгуулалт болно гэж үзэж байгаа юм.

Бусад төслийн үйл ажиллагаа.

- 5 сарын 20: Урт хугацааны мэргэжилтэн Саваикэ Таэко (Нийгмийн даатгалын салбарын чадавхийг бэхжүүлэх төсөл) ирэв.
- 5 сарын 28: Урт хугацааны мэргэжилтэн Цүйки Мао (Мал эмнэлэг, Мал аж ахуйн салбарын хүний нөөцийн хөгжлийн чадавхийг бэхжүүлэх төсөл.) ирэв.
- 5 сарын 29: Урт хугацааны мэргэжилтэн Ёшиока Шизука (Мал эмнэлэг, Мал аж ахуйн салбарын хүний нөөцийн хөгжлийн чадавхийг бэхжүүлэх төсөл.) буцав.
- 5 сарын 30: Урт хугацааны мэргэжилтэн Хаякава Сакико ("Малын цусны шимэгч, эгэл биетнээр үүсгэгддэг өвчний тархалтын судалгаа, оношлогооны оновчтой арга боловсруулах нь" төсөл) буцав.

ЖАЙКА-ийн сайн дурын гишүүдийн үйл ажиллагааны танилцуулга

Сургуулийн өмнөх боловсролыг улам сайжруулах чиглэлд



Монголын томоохон хотуудын нэг Эрдэнэтэд сайн дурын гишүүн Касугай Рина, Ямагүчи Михо нар сургуулийн өмнөх боловсролын байгууллагад үйл ажиллагаа явуулж байна. Тэд монгол багш нартайгаа хамтран хүүхдүүдэд өглөөний дасгал, дуу бүжиг болон хөгжөөнт тоглоом зааж танилцуулахын зэрэгцээ бага насны хүүхдийн аюулгүй орчныг бүрдүүлэх, гар, шүдээ угаах зэрэг эрүүл ахуйн дадал зуршилд сургах тал дээр анхаарч ажилладаг. Түүнчлэн хүүхэд төвтэй боловсролыг практикт нэвтрүүлэх зорилгоор сургалтуудыг зохион байгуулж байна. Хоёр сайн дурын гишүүний хамтран гаргасан "Сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагааны эмхэтгэл" (олныг хамарсан хөгжөөнт тоглоом болон гарын доорх материал ашиглан бүтээл хийх тухай)-ийг сайн дурын гишүүдийн боловсролын салбар зөвлөлийн [Цахим хуудсанд](#) нийтэлсэн тул үзэж сонирхоно уу.

Сайн дурын гишүүдийн бусад үйл ажиллагаа

• Дэлхий даяарх ЖАЙКА-ийн сайн дурын гишүүдийн үйл ажиллагааны тэмдэглэл: Сайн дурын гишүүн Абэ Ёшими (2018 оны 1-р ээлж /Дуу хөгжим/ Сэлэнгэ аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар) [Нийтлэлийн эх1](#)
[Нийтлэлийн эх2](#)



ЖАЙКА-ийн Сургалт Төгсөгчдийн Холбоо

2018 оны шилдэг туршлага нэвтрүүлэгч (2)



Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн Арга зүйч Ч.Жаргал 2015 оны 8–9 дүгээр сард ЖАЙКА-ийн Ёкохама дахь сургалтын төв дээр зохион байгуулагдсан “Тэгш хамруулан сургах боловсрол, тусгай хэрэгцээт боловсролыг дэмжих сургалт”-нд хамрагдсан. Уг сургалтанд хамрагдсанаас хойш 4 жилийн хугацаанд багш нар болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд чиглэсэн олон төрлийн сургалт явуулах зэргээр хот хөдөөгийн 6000 орчим багш ажилтанд сурсан мэдсэнээ хуваалцаж, хэд хэдэн гарын авлага эмхэтгэж гаргасан. Түүний энэхүү хүчин чармайлтыг өндрөөр үнэлэн ЖАЙКА-ийн Сургалт Төгсөгчдийн Холбооны “2018 оны шилдэг туршлага нэвтрүүлэгч”-ээр шалгарууллаа.

[Холбооны цахим хуудас](#)

Бие даасан захиргааны хуулийн этгээд Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага.(ЖАЙКА)
Монгол дахь төлөөлөгчийн газар.
Бодь цамхаг, 7 давхар, Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар, Монгол улс
(Төв шуудан, шуудангийн хайрцаг: 682, Улаанбаатар 15160, Монгол улс)
Утас:+976-325939, 311329, Факс:+976-310845 / E-mail: mg_oso_rep@jica.go.jp
Web: www.jica.go.jp/mongolia/index.html / FB: [JICA Mongolia](#)